

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код : ДАА-2025/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn
Улаанбаатар хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089, 99023682
Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 99036806 Цахим хаяг:
Batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 99377479 Цахим хаяг:
Battsetsegs@audit.gov.mn
Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ
аудит ХХК
Утас: 99197346, 88114867 Цахим хаяг:
Shinjlenmagadlahui.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 107

танай _____-ны № _____-т

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН СУМЫН
30 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4525020161

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус сургуулийн цалингийн зардал 264,192.1 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 33.1 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургууль нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,188,547.38	351,135,787.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	69,464,480.31	346,296,880.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	69,464,480.31	346,296,880.41
3121	Төгрөг	69,464,480.31	346,296,880.41
31211	Төрийн сангийн харилцах	69,464,480.31	346,296,880.41
35	БАРАА МАТЕРИАЛ	4,724,067.07	4,838,907.07
351	Түүхий эд материал	225,350.00	225,350
35130	Эм боох материал	225,350.00	225,350
354	Хангамжийн материал	4,498,717.07	4,613,557.07
35410	Бичиг хэргийн материал	1,040,910.00	447,500.00
35420	Аж ахуйн материал	1,029,892.07	1,429,912.07
35470	Бусад хангамжийн материал	2,427,915.00	2,736,145.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	122,503,997.05	113,035,912.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	122,503,997.05	113,035,912.97
392	Биет хөрөнгө	120,545,663.72	111,577,579.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,536,005.30	149,032,150.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,109,483.74)	(55,735,793.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,408,870.00	24,964,880.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,842,660.34)	(9,828,412.15)
39217	Ном	4,552,932.50	3,144,755.00
393	Биет бус хөрөнгө	1,958,333.33	1,458,333.29
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300)	(1,124,300)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000	2,000,000
39304	Хуримтлагдсан элэгдэл	(41,666.67)	(541,666.71)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196,692,544.43	464,171,700.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	196,692,544.43	464,171,700.45
51	Засгийн газрын хувь оролцоо	196,692,544.43	464,171,700.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	36,180,641.27	36,180,641.27
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	36,180,641.27	36,180,641.27
512	Хуримтлагдсан үр дүн	160,511,903.16	427,991,059.18
51210	Өмнөх үеийн үр дүн	160,511,903.16	160,511,903.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	267,479,156.02
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	196,692,544.43	464,171,700.45




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	401,434,423.00	617,104,445.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,241,423.00	3,558,745.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,241,423.00	3,558,745.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	296,800.00	1,072,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	296,800.00	1,072,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	74,384,061.00	2,486,435.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	15,560,562.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,193,000.00	613,545,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,193,000.00	612,045,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,193,000.00	612,045,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	266,957,270.72	348,217,111.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	266,957,270.72	348,217,111.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,957,270.72	348,217,111.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,375,980.00	264,192,088.70
210101	Үндсэн цалин	150,530,635.00	193,077,319.43
210102	Нэмэгдэл	44,342,673.00	63,621,810.27
210104	Урамшуулал	3,502,672.00	7,492,959.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,992,068.67	31,625,714.41
210201	Тэтгэврийн даатгал	16,875,909.76	22,621,071.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,985,402.46	2,451,653.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,588,321.95	1,225,826.94
210204	Ажилгүйдлийн даатгал	318,387.98	987,937.93
210205	Эрүүл мэндийн даатгал	3,224,046.52	4,339,224.54
2104	Хангамж, бараа материалын зардал	6,842,758.00	6,939,146.79
210401	Бичиг хэрэг	1,213,300.00	1,687,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	81,981.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	684,900.00	392,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,156,628.00	3,093,265.00
210408	Бараа материал акталсны зардал	2,787,930.00	1,684,900.00
2105	Нормативт зардал	43,500.00	619,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,500.00	277,000.00
210502	Хоол, хүнс		342,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,401,747.00	2,218,400.00
210604	Урсгал засвар	16,401,747.00	2,218,400.00
2107	Томилолт, зочны зардал	497,400.00	565,000.00



210702	Дотоод албан томилолт	497,400.00	565,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,800.00	4,907,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,800.00	1,072,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	702,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,133,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,507,017.05	37,150,001.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,652,463.60	4,456,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,250.00	5,227,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,354,303.45	27,446,051.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	134,477,152.28	268,887,333.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,408,177.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,408,177.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(1,408,177.50)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	134,477,152.28	267,479,156.02




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөг-өөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>311,489,800.00</u>	<u>614,618,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	296,800.00	1,072,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	296,800.00	1,072,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	296,800.00	1,072,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	296,800.00	1,072,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,193,000.00	613,545,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,193,000.00	612,045,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,193,000.00	612,045,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>235,378,292.27</u>	<u>320,865,899.90</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,378,292.27	320,865,899.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,378,292.27	320,865,899.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,375,980.00	264,192,088.70
210101	Үндсэн цалин	150,530,635.00	193,077,319.43
210102	Нэмэгдэл	44,342,673.00	63,621,180.27
210104	Урамшуулал	3,502,672.00	7,492,959.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,992,068.67	31,625,714.41
210201	Тэтгэврийн даатгал	16,875,864.76	22,621,071.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,985,402.46	2,451,653.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,588,321.95	1,225,826.94
210204	Ажилгүйдлийн даатгал	318,432.98	987,937.93
210205	Эрүүл мэндийн даатгал	3,224,046.52	4,339,224.54
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,800.00	4,205,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,800.00	1,072,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,133,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,713,443.60	19,342,336.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,713,443.60	14,078,836.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,263,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>76,111,507.73</u>	<u>293,752,200.10</u>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)	<u>15,114,530.00</u>	<u>16,919,800.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>15,114,530.00</u>	<u>16,919,800.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	15,114,530.00	16,919,800.00
222001	Тоног төхөөрөмж	13,114,530.00	16,919,800.00
223001	Бусад хөрөнгө	<u>2,000,000.00</u>	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>15,114,530.00</u>	<u>(16,919,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	60,996,977.73	276,832,400.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,467,502.58	69,464,480.31
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,464,480.31	346,296,880.41



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/Төгрөгөөр/	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,180,641.27	-	26,034,750.88	62,215,392.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,180,641.27	-	26,034,750.88	62,215,392.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	134,477,152.28	134,477,152.28
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,180,641.27	-	160,511,903.16	196,692,544.43
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	36,180,641.27	-	160,511,903.16	196,692,544.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,180,641.27	-	160,511,903.16	196,692,544.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	267,479,156.02	267,479,156.02
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,180,641.27	-	427,991,059.18	464,171,700.45



ТГ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү/+/ дутуу/-/	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684,081,800.00	337,785,699.90	(346,296,100.10)	49.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,081,800.00	337,785,699.90	(346,296,100.10)	49.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,081,800.00	337,785,699.90	(346,296,100.10)	49.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562,038,500.00	264,192,088.70	(297,846,411.30)	47.01
210101	Үндсэн цалин	415,817,500.00	193,077,319.43	(222,740,180.57)	46.43
210102	Нэмэгдэл	143,379,700.00	63,621,810.27	(79,757,889.73)	44.37
210104	Урамшуулал	2,841,300.00	7,492,959.00	(4,651,659.00)	263.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,254,800.00	31,625,714.41	(38,629,085.59)	45.02
210201	Тэтгэврийн даатгал	47,773,300.00	22,621,071.15	(25,152,228.85)	47.35
210202	Тэтгэмжийн даатгал	5,620,300.00	2,451,653.85	(3,168,646.15)	43.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,810,200.00	1,225,826.94	(1,584,373.06)	43.62
210204	Ажилгүйдлийн даатгал	2,810,200.00	987,937.93	(1,822,262.07)	35.16
210205	Эрүүл мэндийн даатгал	11,240,800.00	4,339,224.54	(6,901,575.46)	38.60
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1500,000.00	1500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,986,200.00	4,205,760.00	(7,780,440.00)	35.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,072,400.00	1,072,400.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйчилгээ	10,913,800.00	3,133,360.00	(7,780,440.00)	28.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,302,300.00	36,262,136.79	(2,040,163.21)	94.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,038,800.00	30,998,636.79	(2,040,163.21)	93.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,263,500.00	5,263,500.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	684,081,800.00	614,618,100.00	(69,463,700.00)	89.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	612,045,700.00	612,045,700.00	-	100.0

ХТ02430 @ 9023999

131001	Улсын төсвөөс санхүүжих	612,045,700.00	612,045,700.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1500,000.00	1500,000.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	1500,000.00	1500,000.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	70,536,100.00	1,072,400.00	(69,463,700.00)	1.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,072,400.00	1,072,400.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	69,463,700.00	-	(69,463,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	69,464,480.31	69,464,480.31	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	346,296,880.41	346,296,880.41	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.0	10.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1.0	1.0	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	203.00	203.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	203.00	203.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	1	1	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12	12	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	9.0	9.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.0	3.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна. **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургууль нь "Чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, хэл соёл, өв уламжлалаа дээдэлдэг, ёс суртахуунтай, бүтээлч хүүхдийг төлөвшүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах 4 зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаа явуулсан байна.

Зорилго: Чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, хэл соёл, өв уламжлалаа дээдэлдэг, ёс суртахуунтай, бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ.

- Зорилт: 1 Сургуулийн менежментийг шинэчилж, сургалтын чанарт ахиц гаргах
- Зорилт: 2 Их нүүдэл удирдлагын системийг шинэ шатанд хөгжүүлж, виртуаль сонгон судлах хичээлийг аймгийн хэмжээнд турших
- Зорилт: 3 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих
- Зорилт: 4 Суралцагчийн хөгжлийг дэмжих

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024.03.27 өдрийн тогтоол, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128, 2024.12.25 Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тогтоолоор батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг шинэчлэн баталсныг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс
- Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах босго үнийг шинэчлэн тогтоосныг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс
- Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталснаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус тус мөрдөж ажиллахаар заасан байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймаг Дархан сумын 30 дугаар сургууль 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134,477.2 мянган төгрөгөөр буюу 3.2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69,464.5	346,296.9	276,832.4
Авлага	-	-	-
Бараа материал	4,724.1	4,838.9	114.8
Үндсэн хөрөнгө	122,504.0	113,035.9	(9,468.1)
Нийт хөрөнгө	196,692.5	464,171.7	267,479.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	196,692.5	464,171.7	267,479.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	196,692.5	464,171.7	267,479.2

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 346,296.9 мянган төгрөг болж өмнөх оноос 267,479.2 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 336,475.5 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой. Мөн Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна. Бараа үйлчилгээний бусад зардлаас 9,820.6 мянган төгрөгийг хэмнэж, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын 30 дугаар сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар өр, авлага гаргаагүй ажилласан.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,839.0 мянган төгрөг болж 114.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,836.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал худалдан авсан бөгөөд үйл ажиллагаанд 13,037.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн 460.0 мянган төгрөгөөр хичээл үйлдвэрлэлийн дадлагын молбертны хөл сургалтад авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 113,035.9 мянган төгрөг болж 9,468.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,406.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар ангийн тохижилт орчин бүрдүүлэлтээр машин тоног төхөөрөмжийн дансанд 2,486.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө ирснийг орлогоор бүртгэн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамж 2024 оны 01А/313 тоот тушаал, захирлын 2024 оны А/26 тоот тушаалаар 2,762.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 352,424.6 мянган төгрөгөөр тооцон 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн зардлыг 247,330.4 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтийг 247,330.0 төгрөгөөр буюу 26,995.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон, нөхөн хангалтын зардал батлагдсан зэргээс шалтгаалсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 63,863.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 81834, 81835, 81827, 81816 арга хэмжээг санхүүжүүлэхээр 311,193.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, үйл ажиллагааны орлого 296.8 мянган төгрөг байна.урьд оны үлдэгдлээс 8,462.6 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 311,193.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 296.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 250,492.8 мянга төгрөг буюу 78.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 69,464.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802/81834-Боловсролын стандарт хангалт	645,159.1	307,944.6	337,214.5	47.73
2	71802/81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	2,298.4	2,152.4	146.0	93.65
3	71802/81827-Бичиг үсгийн боловсрол	8,727.2	926.5	7,800.7	10.62
4	71802/80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,432.3	1,432.3	-	100
5	71802/80233-Хүүхэд хамгаалал	1,502.2	1,501.3	0.95	99.94
6	71802/80312-Сургалт семинар	1,048.6	681.5	367.2	64.99
7	71802/81605-Эрүүл мэндийг дэмжих	1,092.3	1,075.0	17.3	98.42

8	71802/81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	16,996.5	16,919.8	76.7	99.55
9	71802/81823-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	3,252.8	2,580.0	672.8	79.32
10	71802/81848-Сурах бичгийн түрээс	1,072.4	1,072.4	-	100
11	71802/80111/-Эд хогшил,урсгал засварын зардал	1500.0	1500.0		100.0
	Дүн	684,081.8	337,785.7	346,296.1	49.38

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих

Тайлант онд 24,576.5 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 8 хөтөлбөр боловсруулж төлөвлөсөн. Хичээл үйлдвэрлэлийн зардалд 4,437.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 7,951.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 5,059.8 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх 3,252.8 мянган төгрөг, сургалт, семинар /хичээлээс гадуур/ 722.9 мянган төгрөг, хүүхэд хамгаалах үйлчилгээ 1,084.3 мянган төгрөг, байр ашиглах үйлчилгээ 1,084.3 мянган төгрөгийг шууд худалдан авалтаар тус тус зарцуулсан. 2024 оны 5 сарын төсвөөр тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлын санхүүжилт 16,919.8 мянган төгрөгөөр 6 зөөврийн компьютер, 2 принтер цахим дэлгүүрээс худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам,

гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 266,957.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,339.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан сумын 30 дугаар сургууль нь тодорхой ажлуудыг зохион байгуулж, цалин, нийгмийн даатгалын шитгэлийн зардлыг 336,475.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 9,820.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Үндсэн ажилтан үйлчлэгч, багш, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, гэрээт багш, гэрээт ажилтан, нэмэгдэл цалин авалгүй ажилласан учраас цалин, нийгмийн даатгалын хэмнэлт үүссэн зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Мөн Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн 30 дугаар сургууль нь 2024 онд мэдээлбэл зохих 169 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар цалингийн зардлын данстай холбоотой 3,964,0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аудитаар өгсөн 3,964.0 мянган төгрөгийн нэг зөвлөмжийг давтан шалгахад 100.0 хувь биелүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,964,0	1	3,964,0	100.0
Нийт дүн	1	3,964,0	1	3,964,0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2024 оны эцэст ТӨВЛӨРҮҮЛСЭН ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР ТОВЧ ОРУУЛАХ

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ